| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз    | 00.00                           | 00.00                 | 00.00             |       | 00.00                                  |
| C07 | Тайлант үеийн үр дүн                             | 00.00                           | 00.00                 | 57,448,488.49     |       | 57,448,488.49                          |
| C08 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл            | 211,325,727.71                  | 268,377,819.79        | 454,237,859.38    |       | 933,941,406.88                         |
| D01 | 2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл            | 211,325,727.71                  | 268,377,819.79        | 454,237,859.38    |       | 933,941,406.88                         |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт       | 00.00                           | 00.00                 | 00.00             |       | 00.00                                  |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                       | 211,325,727.71                  | 268,377,819.79        | 454,237,859.38    |       | 933,941,406.88                         |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00                           | 00.00                 | 00.00             |       | 00.00                                  |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт                  | 00.00                           | 00.00                 | 00.00             |       | 00.00                                  |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз    | 00.00                           | 00.00                 | 00.00             |       | 00.00                                  |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү               | 00.00                           | 00.00                 | 00.00             |       | 00.00                                  |
| D08 | Тайлант үеийн үр дүн                             | 00.00                           | 00.00                 | 65,052,489.51     |       | 52,506,724.51                          |
| D09 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл            | 211,325,727.71                  | 268,377,819.79        | 519,290,348.89    |       | 998,993,896.39                         |

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Код    | Үзүүлэлт                                       | Төлөвлөгөө     | Төсвийн гүйцэтгэлийн тайлан |
|--------|------------------------------------------------|----------------|-----------------------------|
| II     | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН              | 833,854,000.00 | 816,405,209.76              |
| 21     | УРСГАЛ ЗАРДАЛ                                  | 833,854,000.00 | 816,405,209.76              |
| 210    | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                | 774,053,800.00 | 756,729,485.76              |
| 2101   | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил              | 492,765,300.00 | 477,880,483.11              |
| 210101 | Үндсэн цалин                                   | 343,171,600.00 | 336,967,983.03              |
| 210102 | Нэмэгдэл                                       | 81,649,700.00  | 77,852,873.93               |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт                          | 21,944,000.00  | 18,714,804.00               |
| 210104 | Урамшуулал                                     | 46,000,000.00  | 44,344,822.15               |
| 2102   | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 61,595,700.00  | 60,669,235.38               |
| 210201 | Тэтгэврийн даатгал                             | 41,885,100.00  | 42,169,560.71               |
| 210202 | Тэтгэмжийн даатгал                             | 4,927,700.00   | 4,961,124.36                |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал                              | 3,942,100.00   | 3,841,219.38                |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал                           | 985,500.00     | 881,575.63                  |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал                          | 9,855,300.00   | 8,815,755.30                |

|             |                                                                      |                       |                       |
|-------------|----------------------------------------------------------------------|-----------------------|-----------------------|
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                     | <b>82,524,300.00</b>  | <b>81,554,763.27</b>  |
| 210301      | Гэрэл, цахилгаан                                                     | 4,090,200.00          | 3,920,787.11          |
| 210302      | Түлш, халаалт                                                        | 76,139,200.00         | 76,139,144.51         |
| 210303      | Цэвэр, бохир ус                                                      | 2,294,900.00          | 1,494,831.65          |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                              | <b>42,183,600.00</b>  | <b>42,044,236.00</b>  |
| 210401      | Бичиг хэрэг                                                          | 7,718,900.00          | 7,714,671.00          |
| 210402      | Тээвэр, шатахуун                                                     | 26,331,600.00         | 26,331,600.00         |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                                   | 5,974,200.00          | 5,840,010.00          |
| 210405      | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал            | 480,900.00            | 480,000.00            |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                          | 1,678,000.00          | 1,677,955.00          |
| <b>2105</b> | <b>Нормативт зардал</b>                                              | <b>7,674,300.00</b>   | <b>7,649,140.00</b>   |
| 210501      | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл                                      | 6,115,000.00          | 6,115,000.00          |
| 210502      | Хоол, хүнс                                                           | 1,559,300.00          | 1,534,140.00          |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                             | <b>35,336,400.00</b>  | <b>35,291,418.00</b>  |
| 210601      | Багаж, техник, хэрэгсэл                                              | 11,785,000.00         | 11,785,000.00         |
| 210603      | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл                                         | 7,142,900.00          | 7,100,000.00          |
| 210604      | Урсгал засвар                                                        | 16,408,500.00         | 16,406,418.00         |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>                                        | <b>39,748,700.00</b>  | <b>39,748,000.00</b>  |
| 210702      | Дотоод албан томилолт                                                | 39,748,700.00         | 39,748,000.00         |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | <b>6,431,900.00</b>   | <b>6,099,210.00</b>   |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,170,600.00          | 3,170,000.00          |
| 210802      | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                             | 1,386,700.00          | 1,152,000.00          |
| 210803      | Даатгалын үйлчилгээ                                                  | 350,000.00            | 322,050.00            |
| 210804      | Тээврийн хэрэгслийн татвар                                           | 460,000.00            | 448,160.00            |
| 210805      | Тээврийн хэрэгслийн оношлогоо                                        | 144,000.00            | 143,000.00            |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                      | 479,000.00            | 479,000.00            |
| 210807      | Газрын төлбөр                                                        | 50,000.00             | 50,000.00             |
| 210809      | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх                               | 391,600.00            | 335,000.00            |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                               | <b>5,793,600.00</b>   | <b>5,793,000.00</b>   |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 3,500,000.00          | 3,500,000.00          |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                    | 2,293,600.00          | 2,293,000.00          |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                              | <b>59,800,200.00</b>  | <b>59,675,724.00</b>  |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>                                        | <b>59,800,200.00</b>  | <b>59,675,724.00</b>  |
| 213207      | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж                  | 54,640,200.00         | 54,616,024.00         |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                              | 5,160,000.00          | 5,059,700.00          |
| <b>III</b>  | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                                | <b>833,854,000.00</b> | <b>816,405,209.76</b> |
| <b>31</b>   | <b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                                       | <b>833,854,000.00</b> | <b>816,405,209.76</b> |
| 310001      | Улсын төсвөөс санхүүжих                                              | 833,854,000.00        | 816,405,209.76        |
| <b>61</b>   | <b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>                                              | <b>1</b>              | <b>1</b>              |
| 610001      | Төсвийн байгууллага                                                  | 1                     | 1                     |
| <b>62</b>   | <b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>                                              | <b>44</b>             | <b>44</b>             |
| 620001      | Удирдах ажилтан                                                      | 1                     | 1                     |
| 620002      | Гүйцэтгэх ажилтан                                                    | 28                    | 28                    |
| 620003      | Үйлчлэх ажилтан                                                      | 15                    | 15                    |

## **САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газар нь тус аймгийн нутаг дэвсгэрт Монгол улсын хууль тогтоомж, стандартын хэрэгжилтэд төрийн захиргааны хяналт тавих замаар хүний болон нийгмийн тогтвортой хөгжил, иргэд аж ахуйн нэгжийн бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээ хэрэглэх, хөдөлмөрлөх нөхцөлийг бүрдүүлэх эрхэм зорилгын дор үйл ажиллагаа явуулдаг, Мэргэжлийн хяналтын Ерөнхий газарт санхүүгийн тайлангаа нэгтгүүлдэг, Монгол улсын Шадар сайдын харьяа байгууллага юм.

Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газар нь тайлант онд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Мэргэжлийн хяналтын байгууллагын эрхзүйн орчныг боловсронгуй болгож, хөгжлийн бодлогыг тодорхойлно.
- Байгууллагын шинэчлэлийг дэмжсэн хөрөнгө оруулалтыг бий болгоно.
- Дотоод хяналт шалгалт, аудитын ажлыг сайжруулж, сахилга хариуцлагыг нэмэгдүүлнэ.
- Тэрбум мод үндэсний хөдөлгөөн, аймгийн “Ногоон хөгжил бизнес эрхлэгчдийг дэмжих жил”-ийн хүрээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.

Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газар нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 12 зорилт, хэрэгжүүлэх 38 арга хэмжээтэй баталснаас нийт 95.0 хувьтай дүгнэгдсэн байна.

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газар нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар нь дотоод аудитын үйл ажиллагааг удирдан явуулдаг бөгөөд газрын даргын 2022 оны А/03 дугаар тушаалаар дотоод хяналт, шалгалтын зөвлөлийг 5 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн баталж Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу үйл ажиллагаа явуулж байна.

Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газарт Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар болон аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын албаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газар нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2016 оны 12 дугаар сарын 20-ны А/171 дугаар тушаалаар батлагдсан шинэчилсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа ба тус бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай нийцэж байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газар нь 2022 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 65,052.4 мянган төгрөгөөр буюу 6.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт                                     | Эхний<br>үлдэгдэл | Эцсийн<br>үлдэгдэл | /мянган төгрөгөөр/<br>Өөрчлөлт |
|----------------------------------------------|-------------------|--------------------|--------------------------------|
|                                              |                   |                    | 3=2-1                          |
| <b>Б</b>                                     | <b>1</b>          | <b>2</b>           |                                |
| Мөнгөн хөрөнгө                               | 0.0               | 0.0                | 0.0                            |
| Авлага                                       | 0.0               | 0.0                | 0.0                            |
| Бараа материал                               | 77,699.0          | 31,079.2           | -46,619.8                      |
| Үндсэн хөрөнгө                               | 856,242.3         | 967,914.6          | 111,672.3                      |
| <b>Нийт хөрөнгө</b>                          | <b>933,941.4</b>  | <b>998,993.8</b>   | <b>65,052.4</b>                |
| Өр төлбөр                                    | 0.0               | 0.0                | 0.0                            |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/     | 933,941.4         | 998,993.8          | 65,052.4                       |
| <b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b> | <b>933,941.4</b>  | <b>998,993.8</b>   | <b>65,052.4</b>                |

Дээрх хүснэгтээс харахад: Тайлант онд бараа материал дансны эхний үлдэгдэл 77,699.0 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 31,079.2 мянган төгрөг болж нэмэгдсэн болон хасагдсан бараа материалын зөрүү 46,619.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 856,242.3 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 967,914.6 мянган төгрөг болж, 111,672.3 мянган төгрөгөөр өссөн нь нэмэгдсэн болон

хасагдсан үндсэн хөрөнгөөс гадна элэгдлийн зардалтай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 998,993.8 мянган төгрөг болж 65,052.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Мөнгөн хөрөнгө, авлага, өглөгийн данс эхний, эцсийн үлдэгдэлгүй байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,232,923.4 мянган төгрөг, өөрийн үйл ажиллагааны орлогоос 5,000.0 мянган төгрөг, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнээс 321,495.1 мянган төгрөг, нийт 1,559,418.5 төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газраас дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 695,028.5 мянган төгрөгөөр бууруулан 2022 оны урсгал зардлын төсвийг 864,390.0 мянган төгрөгөөр, өөрийн үйл ажиллагааны орлогоос 4,000.0 мянган төгрөгөөр тус тус баталж ирүүлсэн байна.

Энэ нь хөрөнгө оруулалтын зардал 321,495.1 мянган төгрөг болон урсгал зардлаас хасаж баталснаас шалтгаалсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөв 864,390.0 мянган төгрөгөөс 6 удаа тодотгол хийж 833,854.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 833,854.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 17,448.7 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 816,405.2 мянган төгрөг буюу 97.9 хувьтай байгаа нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, байр ашиглалттай холбоотой зардал, хангамжийн бараа материалын зардлуудыг тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

| /мянган төгрөгөөр/ |                                                     |             |             |          |         |
|--------------------|-----------------------------------------------------|-------------|-------------|----------|---------|
| д/д                | Хөтөлбөр, арга хэмжээ                               | Төлөвлөгөө  | Гүйцэтгэл   | Зөрүү    | Биелэлт |
| 1                  | 70417/80101 Үндсэн үйл ажиллагааны зардал           | 772,883.2   | 755,559.5   | 17,323.7 | 97.7%   |
| 2                  | 70417/80205 Мэдээлэл сурталчилгааны зардал          | 420.6       | 420.0       | 0.6      | 99.8%   |
| 3                  | 70417/80227 Лабораторийн итгэмжлэл                  | 1,008.5     | 1,008.5     | 0.0      | 100%    |
| 4                  | 70417/80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал | 59,800.2    | 59,675.7    | 124.5    | 99.8%   |
|                    | ДҮН                                                 | 1,712,317.4 | 1,673,580.5 | 38,736.9 | 97.9%   |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд тендерийн хураамж 35.0 мянган төгрөг орж оны эцэст төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

#### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

*Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт*

| /мянган төгрөгөөр/ |          |                       |                   |                  |                 |            |
|--------------------|----------|-----------------------|-------------------|------------------|-----------------|------------|
| №                  | Хөтөлбөр | Хэрэгжих хугацаа      | Хүрэх үр дүн      | Хэрэгжилтийн явц | Зарцуулах төсөв | Зарцуулсан |
| 1                  | 70417    | 2022.01.01-2022.12.31 | Мэргэжлийн хяналт | Хөтөлбөр 95.0 %  | 833,854.0       | 816.405.2  |



## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Хүрэлбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-нд ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Улсын ерөнхий Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны баталсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газрын батлагдсан 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт орлого 988,804.0 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 14,832.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 11,124.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газарт авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад мэдээлбэл зохих 171 мэдээллээс хугацаандаа мэдээлсэн 155, хугацаа хоцроосон 2, мэдээлээгүй 13 мэдээлэл байна. Цалингаас бусад орлогын 1, зарлагын 2 гүйлгээг мэдээлээгүй байна.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газрын эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитын явцад асуудлын бүртгэлээр 1 зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад үр дүнтэй хэрэгжсэн тул аудитын тайланд тусгаагүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 252 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт        | Өмнөх аудитын үзүүлэлт |                 | Биелэлт  |                 |             |
|-----------------|------------------------|-----------------|----------|-----------------|-------------|
|                 | Тоо                    | Дүн             | Тоо      | Дүн             | Хувь        |
| Акт             |                        |                 |          |                 |             |
| Албан шаардлага | 1                      | 713.0           | 1        | 713.0           | 100%        |
| Зөвлөмж         | 2                      | 19,291.7        | 2        | 19,291.7        | 100%        |
| <b>Нийт дүн</b> | <b>3</b>               | <b>20,004.7</b> | <b>3</b> | <b>20,004.7</b> | <b>100%</b> |

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газар нь татан буугдсан тул хаалтын тайлангаас өмч хөрөнгийн шийдвэрүүдийг шалгах нь зүйтэй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

### 5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 12,545.7 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залрууллаа.Үүнд:

1. Нийт 12,545.7 мянган төгрөгийн бараа материалыг шийдвэргүйгээр аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтэст шилжүүлж, данснаас хассан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

### 5.3 Албан шаардлага

1.Тус байгууллага тайлант онд сургалт зөвлөгөөн зохион байгуулахад 5,003.0 мянган төгрөг зарцуулсан зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-д “Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

- Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.4-д “төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нийцлийн аудиттай холбоотой асуудал

#### Илрүүлэлт:

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад оруулбал зохих 171 мэдээллээс хугацаандаа мэдээлсэн 155, хугацаа хоцроосон 2, мэдээлээгүй 13 мэдээлэл байна. Цалингаас бусад орлогын 1, зарлагын 2 гүйлгээг мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

---

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Шилэн дансанд байршуулбал зохих мэдээлээгүй мэдээллүүдийг нөхөж мэдээлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны<br>товч утга                   | Нийт алдаа |          | Мэдээллийг<br>тусгахгүй<br>орхигдуулсан |          | Буруу<br>тусган<br>илэрхийлсэ<br>н |     | Үүнээс     |          |                  |     | Зөвлөмж |     |
|----------------------------------------|------------|----------|-----------------------------------------|----------|------------------------------------|-----|------------|----------|------------------|-----|---------|-----|
|                                        |            |          |                                         |          |                                    |     | Залруулсан |          | Залруулаагү<br>й |     |         |     |
|                                        | Тоо        | Дүн      | Тоо                                     | Дүн      | Тоо                                | Дүн | Тоо        | Дүн      | Тоо              | Дүн | Тоо     | Дүн |
| Тайлагнал<br>тай<br>холбоотой<br>алдаа | 1          | 12,545.7 | 1                                       | 12,545.7 |                                    |     | 1          | 12,545.7 |                  |     |         |     |
| Дүн                                    | 1          | 12,545.7 | 1                                       | 12,545.7 |                                    |     | 1          | 12,545.7 |                  |     |         |     |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга                     | Нийт зөрчил |         | Үүнээс        |  |                 |         |         |     |                                      |                     |                                                 |  |
|----------------------------------------|-------------|---------|---------------|--|-----------------|---------|---------|-----|--------------------------------------|---------------------|-------------------------------------------------|--|
|                                        |             |         | Төлбөрийн акт |  | Албан шаардлага |         | Зөвлөмж |     | Хариуцлага тооцуулах албан шаардлага |                     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |  |
|                                        | Тоо         | Дүн     |               |  |                 |         |         |     |                                      |                     |                                                 |  |
| Хууль тогтоомжийн хэрэгжилт хангаагүй. | 2           | 5,003.0 |               |  | 1               | 5,003.0 | 1       | 0.0 |                                      | Албан тушаалтны тоо |                                                 |  |
| Дүн                                    | 2           | 5,003.0 |               |  | 1               | 5,003.0 | 1       | 0.0 |                                      |                     |                                                 |  |